

“ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА”-ЫН НЭР ТОМЬЁОНЫ ОЙЛГОЛТ, ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ НЬ

Б.БАТБОЛД

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн удирдлага, стратегийн профессорын багийн профессор,
докторант, хурандаа

Товч агуулга: Сүүлийн жилүүдэд төрийн байгууллага, албан тушаалтан болон иргэд, хуулийн этгээд Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийг буруу хэрэглэх, өөр өөрийнхөөрөө тайлбарлан хэрэглэх нь наад захын үзэгдэл болжээ.

Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийг бүх нийтээрээ нэг мөр зөв хэрэглэх нь чухал бөгөөд төрийн байгууллагын нэр томьёоны тодорхойлолтыг судалж, дүн шинжилгээ хийсэн.

Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг судалж, цаашид хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийг бүх нийтээрээ нэг мөр зөв хэрэглэх, ХЗДХЯам, ДХИС-ийн эрдэмтэн судлаач, цагдаа, хил, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдал болон шүүхийн шинжилгээний байгууллагуудын албан хаагч нартай ярилцлага, санал асуулга явуулж, дүн шинжилгээ хийн, санал гаргав.

Түлхүүр үгс: Төрийн байгууллагын нэр томьёог нэг мөр зөв хэрэглэх нь.

Оршил

Монгол Улсын Үндсэн хуулийн хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэг “Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна”, мөн арван долдугаар зүйлийн 1.1 дэх заалтад “Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх” гэж тунхагласан байдаг.

Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт “Монгол Улсын Үндсэн хууль, энэ хуулиас бусад хууль хоорондоо зөрчилдөөл тухайн асуудлыг илүү нарийвчлан зохицуулсан хуулийн, тийм хууль байхгүй бол сүүлд хүчин төгөлдөр болсон хуулийн заалтыг хэрэглэнэ”¹ гэж хуульчилсан. Гэтэл төрийн байгууллага, албан тушаалтан болон иргэд хуулийг өөр өөрийнхөөрөө тайлбарлах, Улсын Их Хурлаас батлан гаргаагүй нэр томьёог хэрэглэх явдал ихсэх хандлагатай болжээ.

Бид Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийг нэг мөр зөв ойлгож хэрэглээгүйгээс болон шинээр батлагдсан хууль тогтоомж, эрх зүйн актыг эрх бүхийн байгууллага, албан тушаалтан хууль сурталчлах ажлыг хангалттай явуулаагүйгээс үүдэн иргэд, төрийн байгууллага, албан тушаалтан хууль тогтоомжийг буруу ойлгох, практикт өөр өөрсдийнхөөрөө ойлгож хэрэглэсээр

байна. Цаашид хууль тогтоомжийг нэг мөр зөв хэрэглэх, наад зах нь төрийн байгууллагын нэр томьёог зөв хэрэглэж, өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэглэх нь зүйтэй юм.

Нэг.Төрийн байгууллагын нэр томьёоны хэрэглээ

Бид сүүлийн жилүүдэд төрийн байгууллагыг доорх байдлаар нэршлийг өөрөөрийнхөөрөө тайлбарлан хэрэглэх болжээ. Тухайлбал:

- 1.Төрийн байгууллага;
- 2.Хуулийн байгууллага;
- 3.Хууль, шүүхийн байгууллага;
- 4.Хууль, хүчний байгууллага;
- 5.Хууль, хяналтын байгууллага;
- 6.Хууль хэрэгжүүлэх байгууллага;
- 7.Хууль сахиулах байгууллага;
- 8.Хууль зүйн салбарын байгууллага;
- 9.Цэрэг, цагдаагийн байгууллага;
- 10.Хүчний байгууллага;
- 11.Үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллага;

¹Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=299>

12.Практик байгууллага;

13.Цэргийн байгууллага;

14. Төрийн тусгай байгууллага, /Төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага/

15. Төрийн захиргааны байгууллага гэх мэт маш олон томьёогоор хэрэглэж байгаа нь хуулийг нэг мөр зөв хэрэглэж хэвшээгүйн нэгэн илрэл юм.

2012 онд хууль зүйн салбарын шинэчлэлийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 87 дугаар тогтоолоор Дотоод хэргийн их сургуулийг Хууль сахиулахын их сургууль болгон өөрчлөн зохион байгуулсан². Учир нь тухайн үеийн Засгийн газрын 2012-2016 оны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор “Хууль сахиулах ажиллагааны тухай хууль” шинээр боловсруулж, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 05 дугаар сарын 13-ны өдөр хаврын чуулганаар уг хуулийг анхны хэлэлцүүлгээр хэлэлцүүлэн баталсан байдаг.

Энэ шинэчлэлийн хүрээнд үед төрийн зарим байгууллагуудыг хууль сахиулах байгууллага гэж нэрлэх нь ихсэх хандлагатай болсон гэж үздэг. Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр батлан гаргасан Эрүүгийн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт ... “Тайлбар: -Энэ хуульд заасан “хууль сахиулагч” гэж цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, төрийн тусгай хамгаалалтын албаны алба хаагч, хуулиар тусгайлан эрх олгосон эрх бүхий этгээд, байгаль хамгаалагчийг ойлгоно”³ гэж заасан.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2015 оны 08 дугаар сарын 07-ны өдөр батлан гаргасан Галт зэвсгийн тухай хуулийн 4 зүйлийн 4.1.3 дахь заалтад “Хууль сахиулах албаны”⁴ гэж хуулиар

нэр томьёоны шинэ тодорхойлолт туссан байна.

Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.7 дахь заалтад “хууль сахиулах бусад байгууллагын үйл ажиллагаанд хуульд заасан эрх хэмжээний хүрээнд дэмжлэг үзүүлэх, мөн хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт “Олон нийтийн цагдаа хууль сахиулах үүрэг гүйцэтгэхдээ хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон бусад хууль тогтоомжийг чанд сахиж, зөвхөн гэрээнд заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ”, 63.10.6 дахь заалтад “нийтийн хэв журам хамгаалах талаар хууль сахиулах байгууллага болон бусад хуулийн этгээдээс зохион байгуулж байгаа ажилд оролцох”⁵ гэж 3 заалт туссан байдаг.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдөр батлан гаргасан Монгол Улсын Хилийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.9 дахь хэсэгт “... хууль сахиулах болон хилийн хяналтын байгууллага, ... чиг үүрэг бүхий Хилийн боомтын захиргааг Засгийн газар байгуулна”⁶ гэж

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдөр батлан гаргасан Хүүхэд хамгаалах тухай хуульд “Хууль сахиулах байгууллага” гэж 5 заалт туссан байна.⁷

Гэтэл Монгол Улсын Их Хурлын 2016 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 26 дугаар тогтоолоор Хууль сахиулах ажиллагааны тухай хуулийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 53 дугаар зүйлд заасан журмын дагуу Улсын Их Хурлын эцсийн найруулгатай танилцах, ёсчлох, Монгол Улсын Ерөнхийлөгчидилгээх, “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд хэвлэн нийтлэх ажиллагаанууд хийгдээгүй

²Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем <https://www.legalinfo.mn/law/details/8763?lawid=8763>

³Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем <https://legalinfo.mn/mn/detail?lawid=11634>

⁴Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем <https://legalinfo.mn/mn/detail?lawid=11270>

⁵Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем <https://legalinfo.mn/mn/detail/12469&menuid=74>

⁶Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем <https://legalinfo.mn/mn/detail?lawid=12418>

⁷Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем <https://legalinfo.mn/mn/detail/11710>

үндэслэлээр хууль санаачлагчид нь буцааж, уг хуулийг батлагдаагүй.⁸

Тэгвэл Монгол Улсын Их Хурлын 1996 оны 05 дугаар сарын 27-ны өдөр баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээрийн 14.1 дэх хэсэгт “Төрийн өмчит үйлдвэрийн газраас бусад улсын төсвөөс санхүүждэг хуулийн этгээдийг төрийн байгууллага, албан газар гэнэ” гэж хуульчилсан.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2011 оны 10 дугаар сарын 20-ны өдөр баталсан Зээлийн мэдээллийн тухай хуулийн “Төрийн байгууллага” гэж “Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо, иргэн, хуулийн этгээдийн болон эд хөрөнгийн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон нийгмийн даатгал, гааль, эрчим хүч, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагыг” хэлнэ гэж хуульчилсан байгааг анхаарах нь зүйтэй юм.

Монгол Улсын Үндсэн хуульд “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална” гэж, “Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн” гэж тус тус заасан бөгөөд бусад байгууллагуудын хувьд “Төрийн байгууллага” байхаар тунхагласан.

Монгол Улсын Засгийн газрын тухай хууль тогтоомжид байгууллагын нэр томъёог доорх байдлаар хуульчилсан байна. Үүнд:

1. Монгол Улсын төрийн гүйцэтгэх дээд байгууллага;
2. Төрийн захиргааны болон төв болон нутгийн захиргааны байгууллага;
3. Нам, олон нийтийн байгууллага;
4. Засгийн газрын бус байгууллага;
5. Олон улсын байгууллага;
6. Нэгдсэн үндэстний байгууллага;

7. Шүүх, прокурорын байгууллага⁹ гэсэн нэр томъёотойгоор хуульд туссан байна.

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн баталсан Төрийн албаны тухай хуулийн 6 дугаар зүйлд “Төрийн албаны ангилал”-ыг дор дурдсанаар тодорхойлсон байдаг. Үүнд:

1. Төрийн улс төрийн алба
2. Төрийн захиргааны алба
3. Төрийн тусгай алба
4. Төрийн үйлчилгээний алба гэж тодорхойлсон байдаг.¹⁰

Бид энэ олон томъёоны тодорхойлолтыг халж гагцхүү Монгол Улсын Их Хурлаас батлан гаргасан хууль тогтоомжид заасан нэр томъёогоор хэрэглэж “Төрийн байгууллага” гэсэн нийтлэг нэрийг хэрэглэх хэрэгцээ, шаардлага нэгэнт бий болжээ.

Монгол Улсын Их Хурлаас батлан гаргасан хууль тогтоомжуудын судалж үзэхэд Монгол Улсын Үндсэн хууль Төрийн албаны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын хилийн тухай, Эрүүгийн, Галт зэвсгийн, Хүүхэд хамгаалах тухай хууль гэх мэт хууль тогтоомжууд нь өөр хоорондоо зөрүүтэй, салаа утга агуулсан гэж үзэх үндэслэлтэй байна.

Тэгвэл Дотоод хэргийн их сургуулийн хувьд 1934 оноос хойш өнөөдрийг хүртэл төрийн тусгай албаны албан хаагчдыг бэлтгэж ирсэн Монгол Улсын дээд боловсролын тогтолцоонд баттай байр суурийг эзэлсэн Монгол Улсын үндэсний ууган сургуулиудын нэг бөгөөд их сургуулийн түүхэн 88 жилийн ой энэ жил тохиож байгаа Монгол Улсад байгуулагдсан 2 дахь их сургууль юм.

Дотоод хэргийн их сургууль нь Монгол Улсын Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагууд болох цагдаа, хил хамгаалах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын, шүүхийн шинжилгээний байгууллагуудын болон дотоод цэргийн

⁸Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем
<https://www.legalinfo.mn/law/details/12099?lawid=12099>

⁹Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем
<https://legalinfo.mn/mn/detail?lawid=344>

¹⁰Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем
<https://legalinfo.mn/mn/detail?lawid=13025>

мэргэшсэн хүний нөөцийг Боловсролын тухай, Дээд боловсролын тухай хууль тогтоомжийн хүрээнд бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэхээс гадна судалгааны ажил зонхилсон лаборатори бүхий эрдэм шинжилгээ-сургалт-үйлдвэрлэлийн нэгдэл хэлбэртэй дээд боловсролын сургалтын байгууллага бөгөөд төрийн байгууллага болон их дээд сургуулийн багш, судлаач, албан хаагчдыг магистр, докторын зэргийн сургалтад хамруулж, удирдах ажилтан болон судлаач мэргэжилтэн бэлтгэж гаргадаг онцлогтой сургууль юм.

Гэтэл Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 87 дугаар тогтоолоор Дотоод хэргийн их сургуулийг нэрийг Хууль сахиулахын их сургууль¹¹ болгон өөрчлөн зохион байгуулсан юм.

Монгол Улсын Их Хурлаас “Хууль сахиулах ажиллагааны тухай хууль”-ийг баталж, мөрдөөгүй байхад Дотоод хэргийн их сургуулийн нэрийг Хууль сахиулах их сургууль болгон өөрчилж, улмаар мэргэжлийн индекс, нэршлийг “хууль сахиулагч” гэж өөрчилж, улмаар Хууль сахиулах их сургууль нь хууль сахиулагчдыг бэлтгэн гаргадаг гэсэн нэгдсэн ойлголт зонхилжээ.

Дүгнэлт

Монгол Улсын Их Хурлаас батлан гаргаж буй хууль тогтоомжуудыг болон Монгол Улсын Засгийн газраас гаргасан эрх зүйн актуудыг судалж үзвэл Монгол Улсын Засгийн газар өөрчлөгдөх болгонд төрийн байгууллагын нэр томьёоны тодорхойлолтод өөрчлөлт орж, улмаар салаа утга агуулсан, өөр хоорондоо зөрүүтэй хууль тогтоомжууд Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилсээр байгаа нь дээр дурдсан хуулиудаас харагдаж байна.

Монгол Улсын Их Хурлаас “Хууль сахиулах ажиллагааны тухай хууль”-ийг эцэслэн баталж, мөрдөөгүй байхад Эрүүгийн болон Галт зэвсгийн тухай хууль, Хүүхэд хамгаалах тухай хууль, Монгол Улсын хилийн тухай хууль тогтоомжид “хууль сахиулах байгууллага,

хууль сахиулагч” гэсэн нэр томьёоны тодорхойлолт оруулж баталсан нь Монгол Улсын Үндсэн хууль болон төрийн албаны тухай хууль тогтоомжтой зөрчилдөж байгаа нь илт байна.

Дээрх хуулиудын батлагдсан огноог харахад 2015-2016 онд батлагдсан хуулиуд байна. Өөрөөр хэлбэл дээр дурдсан 2012 онд хууль зүйн салбарын шинэчлэлийн хүрээнд Засгийн газрын 2012-2016 оны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор уг хуулиудыг баталсан гэж үзэхээр байна.

Энэ нь төрийн байгууллагуудын нэр өөрчлөгдөх бүрд тухайн төрийн байгууллагын бэлэг тэмдэг, туг, хаяг, албан бланк, албан хаагчдын дүрэмт хувцас, таних тэмдэг, үнэмлэх зэргийг өөрчлөх шаардлага үүсэж, улмаар тухайн жилийн улсын төсөвт тусгагдаагүй буюу тооцоолоогүй зардлууд гарч, санхүү, эдийн засгийн асуудалд хүндрэл үүсэж, улсын төсвийн үргүй зардал бий болгосоор байна гэж үзэх үндэслэлтэй юм. Мөн энэ нь ард иргэдийн дунд ч төрийн байгууллагуудын нэр томьёог хольж, сольж ярих, буруу ойлгох, төөрөгдөл үүссээр байгаа нь илэрхий юм.

Зөвхөн Дотоод хэргийн их сургуулийн нэрийг Хууль сахиулах их сургууль болгон өөрчилсөн нь их сургуулийн дүрэм, бүтэц, орон тооны өөрчлөлт, архив, албан хэрэг хөтлөлтөд өөрчлөлт орох улмаар мэргэжлийн индекс, нэршлийг “хууль сахиулагч” гэж өөрчилсөн нь цаг үеэ олоогүй шийдвэр байсан гэж үзнэ. Түүнчлэн тухайн үед хууль сахиулагч мэргэжлээр төгссөн төгсөгчид “Эрх зүйч” мэргэжлээр дипломоо гардан аваагүйдээ сэтгэл дундуур байдаг байна. Мөн шийдвэр гүйцэтгэгчийн болон хуульчийн сонгон шалгаруулалтад орох эрхгүй.

Түүнчлэн “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх-хууль сахиулах ажил” мэргэжлээр төгссөн төгсөгчид бусад их дээд сургууль, гадаадын их дээд сургуулийн магистрантурт элсэн суралцах боломжгүй бөгөөд хууль сахиулах гэх мэргэжил нь тухайн сургуулиудын тавигдах шаардлагад

¹¹Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем
<https://www.legalinfo.mn/law/details/8763?lawid=8763>

тохирдоггүй байдал ажиглагдсаар байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн хэрэгжүүлж байгаа “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх-хууль сахиулах” хөтөлбөрөөр суралцаж төгссөн төгсөгчдөд захиалагч байгууллагын зохих албан тушаалд ажиллахад ажлын байрны тодорхойлолтод заасан тавигдах шаардлагад нийцдэггүй. Тухайлбал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, газар, нэгжид ажиллах ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгчийн ажлын байрны тодорхойлолтод эрх зүйч байхаар, хорих байгууллагын харуул хамгаалалт, аюулгүй байдлын чиг үүрэг бүхий алба хаагчдын ажлын байрын тодорхойлолтод эрх зүйч байхаар тус тус заасан байдаг нь сургалт-практик зөрөхөд хүрсэн байна.

Их сургуулийн нэр, мэргэжлийн индекс, нэршил нь олон солигдох бүрд иргэдийн дунд төөрөгдөл үүсэхээс гадна чухам аль сургуулийг нэрлээд байгаад төдийлөн ойлголт байдаггүй. Цагдаагийн академи, Хууль сахиулахын их сургууль гэсэн нэрээр ойлгож байдаг. Мөн шинээр элсэгчдийн хувьд элсэх сургуулийн нэр, сургалтын хөтөлбөрийн индекс жил бүр өөрчлөгдсөнөөр төөрөгдөл үүсдэг. Их сургуулийн нэршлийн хувьд сонирхолтой баримт сонирхуулаад 2009, 2010 онд элсэгчид суралцах хугацаандаа 3 сургуульд суралцсан байдаг. Тухайн үед тус сургуульд элсэхдээ Цагдаагийн академид, суралцах хугацаандаа Дотоод хэргийн их сургуульд харин төгсөхдөө Хууль сахиулахын их сургуулийг төгссөн байх жишээтэй.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хуулиар хууль сахиулагч гэж цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчийг ойлгохоор заасан бол Дотоод хэргийн их сургуулийн хувьд хил хамгаалах, онцгой байдлын, шүүхийн шинжилгээний болон дотоодын цэргийн албан хаагчид хамаарахгүй гэж ойлгохоор байгаа ч Монгол Улсын Үндсэн хууль болон төрийн албаны тухай хууль тогтоомжийн хүрээнд төрийн тусгай албан хаагч гэж ойлгож хэрэглэхээр байгаа нь учир дутагдалтай.

Санал

1. Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт “Монгол Улсын Үндсэн хууль, энэ хуулиас бусад хууль хоорондоо зөрчилдвөл тухайн асуудлыг илүү нарийвчлан зохицуулсан хуулийн заалт, тийм хууль байхгүй бол сүүлд хүчин төгөлдөр болсон хуулийн заалтыг хэрэглэнэ” гэж заасан байх тул бид Монгол Улсын Их Хурлаас батлан гаргасан хууль тогтоомжийг нэг мөр зөв ойлгож хэрэглэх нь зүйтэй юм.

2. Монгол Улсын Их Хурлаас баталсан дээрх зөрчилдөөнтэй хуулиуд нь 2015, 2016 онд батлагдсан байх бөгөөд одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдөр батлагдсан Төрийн албаны тухай хуульд заасны дагуу “Төрийн байгууллага” гэж нэршлээр нэрлэж, ангиллаар нь бол “Төрийн тусгай алба” гэж ангилж байх нь зүйтэй.

3. Цаашид Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж

байгаа хууль тогтоомжийг бүх нийтээрээ нэг мөр зөв хэрэглэх нь чухал бөгөөд төрийн байгууллагын нэр томьёог Монгол Улсын Үндсэн хууль болон Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу нэрлэж хэвших санал гаргав.

Эх сурвалжийн жагсаалт

-Хууль зүй, дотоод хэргийн яамны веб сайт <https://mojha.gov.mn/>

-Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем <https://legalinfo.mn/mn/>

-Дотоод хэргийн их сургуулийн веб сайт <https://www.uia.gov.mn/>

-Хуульчилсан нэр томьёоны толь Ц.Гантулгат 2018 он

-Хууль зүйн тайлбар толь Ж.Амарсанаа, Г.Баясгалан, Ж.Бямбаа, Т.Мөнхжаргал, Г.Совдын, Г.Уранцэцэг 2003 он